



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 4502

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Журмын хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (Я.Буянжаргал)-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 483 дугаар, "Журам, заавар батлах тухай" 487 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ



081969

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11.. сарын 28...ны өдрийн
A/502 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь хүн амд үйлчлүүлэгч төвтэй, үр дүнтэй, цогц сэргээн засах тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.
2. Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-д зааснаас бусад/-д заасан төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад хамаарна.
3. Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусlamж, үйлчилгээний үндсэн зарчмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний үндсэн зарчим

Сэргээн засах тусlamж, үйлчилгээ нь үйлчлүүлэгч шинэ нөхцөл байдалд дасан зохицох, алдагдсан чадвараа хэвийн болго болон боломжит дээд хэмжээнд хүргэхэд "суралцах" үйл явцад тулгуурлах ба дараах зарчимд үндэслэнэ. Үүнд:

- 2.1. Үйлчлүүлэгч бүрийн хувь хүний онцлогт тохирсон;
- 2.2. Зорилгodoо хүрэх дэс дараалал, үе шаттай;
- 2.3. Цогц бүрдэл байх;
- 2.4. Багийн хамтын ажиллагаатай;
- 2.5. Гэр бүл, хамт олны оролцоог хангасан;
- 2.6. Сэргээн засалт нь өвдсэн цаг мөчөөс эхэлж, нийгмийн харилцаа бүрэн; боломжит дээд хэмжээнд сэргэх хүртэл тасралтгүй үргэлжлэх.

Гурав. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний зохион байгуулалт

- 3.1. Өвчин, эмгэг, гэмтлийг сэргээн засах анагаах ухааны үүднээс оношилж, өвчний явц тавиланг үнэлэх, түүнд тохирсон сэргээн засах эмчилгээг төлөвлөх, үндсэн болон хавсарсан өвчний хүндрэл, дахилт, хоёрдогч эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлэх эмчилгээний төлөвлөгөөг боловсруулахад сэргээн засал судлалын эмч тусlamж, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.2. Сэргээн засах судлалын эмч нь багийн үйл ажиллагааг удирдаж, сэргээн засах тусlamж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийн үзлэг оношилгоо, үнэлгээ, төлөвлөгөөг багийн гишүүд болон үйлчлүүлэгч, гэр бүлийн гишүүдтэй хамтран шийдвэрлэнэ.

3.3. Сэргээн засах судлалын эмч, мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид өвчний тавилан, явцын талаар тайлбарлаж, сэргээн засах эмчилгээний агуулга, ач холбогдлын талаар таниулж, зөвшөөрөл авна.

3.4. Сэргээн засах судлалын эмч, мэргэжилтэн нь сэргээн засах эмчилгээний зорилго, зорилтыг төлөвлөхөд өвчтөн тэдний гэр бүлийг оролцуулж шийдвэрлэнэ.

3.5. Сэргээн засах судлалын эмч, мэргэжилтэн нь үйлчлүүлэгч бүрийн хувийн онцлогт тохирсон сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж, түүний дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.6. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтнүүд эмчилгээний үр дүнг тодорхой хугацаанд үнэлж, шаардлагатай бол төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, засаж сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.7. Сэргээн засах судлалын эмч, мэргэжилтэн нь сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийг дараагийн эрүүл мэндийн байгууллагаад шилжүүлэхдээ сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас, эмчилгээний ерөнхий төлөвлөгөөг хөтлөн хүлээлгэн өгч, мэдээллийг хамтран ашиглана.

3.8. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний шалгуурыг ашиглаж үнэлгээг хийнэ.

3.9. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардлагатай үнэлгээний шалгуураар үр дүнг хянаж, бүртгэл судалгааг тогтмол хийдэг байна.

3.10. Физик эмчилгээ, хөдөлгөөн засал эмчилгээний аппарат, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл нь сэргээн засах тусламж, үйлчилгээнд олон улсад нийтлэг ашигладаг, нотолгоонд тулгуурласан байх ба аюулгүй ажиллагааг батлагдсан заавар, журмын дагуу хийнэ.

Дөрөв. Сэргээн засах тусламж, үйлчилгээний үйл явцын дараалал

Сэргээн засах тусламж, үйлчилгээний үйл явц нь дараах дарааллын дагуу тасралтгүй үргэлжилж явагдана. Үүнд:

- 4.1 Сэргээн засах судлалын эмчийн үзлэг, оношилгоо, үнэлгээ, зөвлөгөө;
- 4.2 Хөдөлгөөн, хөдөлмөр, хэл засалчийн үзлэг, үнэлгээ, зөвлөгөө;
- 4.3 Сэргээн засах багийн зөвлөгөөн;
- 4.4 Сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө;
- 4.5 Хувь хүнд тохирсон төлөвлөгөөний дагуу үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ;
- 4.6 Эмчилгээний үр дүнгийн хяналт;
- 4.7 Сэргээн засах багийн давтан үнэлгээ.

Тав. Сэргээн засах тусламж, үйлчилгээний хэлбэр, хугацаа, давтамж

- 5.1. Сэргээн засах судлалын эмчийн нэг удаагийн үзлэг, зөвлөгөөнд 20 минутаас доошгүй хугацаа зарцуулна. Үзлэгийг сэргээн засахын тусламж, үйлчилгээний стандарт, эмнэл зүйн зааврын дагуу хийнэ. Сэргээн засахын анхан шатны бүртгэл, үнэлгээний хуудсыг ашиглана.
- 5.2. Хөдөлгөөн, хөдөлмөр, хэл засалч нь мэргэжлийн үнэлгээ, эмчилгээг гардан гүйцэтгэх хугацаа 20-оос доошгүй минут байна.
- 5.3. Өвчний оношоос хамааруулан 2-оос доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзнэ.
- 5.4. Хэвтүүлэн эмчлэх сэргээн засах тусламж, үйлчилгээг 5-оос доошгүй хоногоор үзүүлнэ.
- 5.5. Өдрийн сэргээн засах тусламж, үйлчилгээг 5-оос доошгүй хоногоор үзүүлнэ.
- 5.6. Амбулаторийн сэргээн засах тусламж, үйлчилгээг нэг удаад 1 хүртэлх цагаар үзүүлнэ.

5.7. Гэрийн сэргээн засах тусламж, үйлчилгээг нэг удаад 2 хүртэлх цагаар нийтдээ 5-оос доошгүй хоногоор үзүүлнэ.

Зургаа. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаа

6.1 Нийтлэг үүрэг, үйл ажиллагаа

6.1.1. Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусламж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад илгээх, эмнэлгийн байгууллагын хооронд шилжүүлэх, хулээн авах, бүртгэх, нэгтгэн мэдээлэх, тайлагнах, тасралтгүй хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

6.1.2. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас болон эмчилгээний ерөнхий төлөвлөгөөг хөтөлж, эмнэлгийн байгууллага хоорондын бүртгэл болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн санг бий болгож ажиллана.

6.1.3. Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах судлалын эмч, сувилагч, сэргээн засахын мэргэжилтнийг тасралтгүй сургалтад тогтмол хамруулж, мэдлэг ур чадвар, хандлагыг дээшлүүлэхэд санаачлага, идэвх чармайлт гаргаж ажиллана.

6.1.4. Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгч, түүний гэр булийн гишүүдэд үйл ажиллагааны чадвар алдагдал, түүнд хургэх эрсдэлд хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ажиллана.

6.1.5. Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах багийн тусламж, үйлчилгээг шаардлагатай хүний нөөцийг зөв зохистой бүрдүүлж үзүүлнэ.

6.1.6. Эрүүл мэндийн байгууллага нь сэргээн засах тусламж, үйлчилгээнд шаардлагатай орчин, аппарат, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрдүүлж, батлагдсан стандарт, эмчилгээний заавар удирдамжийг мөрдөж ажиллана.

6.2. Өвөрмөц үүрэг, үйл ажиллагаа

6.2.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сувилахуйн төв нь сэргээн засах тусламж, үйлчилгээг гэрээр болон өдрийн хэлбэрээр үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмчилгээг дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх бичгээр шилжүүлнэ.

6.2.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамж, аргачлал, зааврын дагуу үзүүлнэ.

6.2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтэн нь сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэшлийн сургалтад хамрагдсан байна.

6.2.4. Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн ортой төв, амаржих газар, сувилал, сэргээн засах төв, тусгай эмнэлэг нь тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн болон өдрийн хэлбэрээр мэргэшсэн багаар үзүүлж, эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай бол зохих шатны эрүүл мэндийн байгууллагад илгээх бичгээр шилжүүлнэ.

Долоо. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний төрөл

- 7.1. Сэргээн засахын оношилгоо, үнэлгээ:
 - 7.1.1. Сэргээн засахын оношилгоо, үзлэгийн аргууд;
 - 7.1.1. Алхааны үнэлгээ.
- 7.2. Сэргээн засах эмчилгээний аргууд:
 - 7.2.1. Эмчилгээний дасгал;
 - 7.2.2. Үений далайцын дасгал;
 - 7.2.3. Булчингийн хүч хөгжүүлэх эсэргүүцэлтэй дасгал;
 - 7.2.4. Сунгалтын дасгал;
 - 7.2.5. Аеробик дасгал;
 - 7.2.6. Үл ашиглах хамшинжийн оношилгоо, эмчилгээ.
- 7.3. Хөдөлгөөн засал
- 7.4. Хөдөлмөр засал
- 7.5. Физик эмчилгээ
- 7.6. Гар засал
- 7.7. Хэл засал
- 7.8. Мэдрэл-сэтгэлзүйн тусlamж, үйлчилгээ
- 7.9. Сэтгэцийн тусlamж, үйлчилгээ
- 7.10. Хоол эмчилгээ
- 7.11. Туслах хэрэгслүүд, хиймэл эрхтэн
- 7.12. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ

Найм. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний оношилгоо, үнэлгээ

- 8.1. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний оношилгоо, үнэлгээний аргуудад дараах зарчмуудыг баримтална. Үүнд:
 - 8.1.1 Олон улсын хэмжээнд нийтлэг ашиглагддаг байх;
 - 8.1.2 Өдөр тутмын практикт ашиглагддаг оношилгооны арга байх;
 - 8.1.3 Найдвартай байдал болон хүчин төгөлдөр байдал нь баталгаажсан байх.
- 8.2. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний оношилгоо, үнэлгээнд дараах аргуудыг ашиглана. Үүнд:
 - 8.2.1. Асуумж авах;
 - 8.2.2. Бодит үзлэг хийх.
- 8.3. Сэргээн засах тусlamж, үйлчилгээнд дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно. Үүнд:
 - 8.3.1. Өвдөлтийн хүч, шинж чанар;
 - 8.3.2. Биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын түвшин;
 - 8.3.3. Биеийн үйл ажиллагааны хязгаарлагдмал байдал;
 - 8.3.4. Чадвар алдагдлын түвшин буюу зорилгот үйлийн хязгаарлалт;
 - 8.3.5. Нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдал;
 - 8.3.6. Орчны болон хувь хүний хүчин зүйл;
 - 8.3.7. Амьдралын чанарын түвшин;
 - 8.3.8. Ортез, протез, туслах хэрэгслийн хэрэгцээ

Ес. Сэргээн засах тусlamж, үйлчилгээний үр дүнг тооцох

Оношилгоо, үнэлгээний үнэн зөв мэдээлэл, сэргээн засах тусlamж, үйлчилгээний арга хэлбэрийн оновчтой сонголт, нотолгоонд суурилсан эмнэлгийн сэргээн засах

тусламж, үйлчилгээ, нийгэм, хамт олон, гэр бүлийн дэмжлэгт үйл ажиллагаанаас гарах үр дүнг доорх үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр тооцно. Үүнд:

- 9.1. Өвдөлтийн хүч, эрчим буурсан байдал;
- 9.2. Үйл ажиллагааны чадвар сайжирсан байдал;
- 9.3. Зорилгот үйлийн чадвар сайжирсан байдал;
- 9.4. Нийгмийн оролцоо сайжирсан байдал;
- 9.5. Амьдралын чанар сайжирсан байдал;
- 9.6. Үндсэн эмгэгийн эмчлэгдсэн байдал;
- 9.7. Хүндрэл, дахилтын байдал;
- 9.8. Ортез, протез, туслах хэрэгслийн хэрэгслийг зөв хэрэглэж, ашигласан байдал;
- 9.9. Амьдралын шинэ арга барилд суралцсан байдал.

Арав. Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, үнэлгээний нэр төрлийн жагсаалт

10.1 Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, үнэлгээний нэр төрөл

№	Оношилгоо, үнэлгээний ерөнхий агуулга	Тусгай агуулга	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, Сувилахуйн төв, Сувилал	Амаржих газар	Нэгдсэн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв	Сэргээн засах төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай эмнэлэг
1	Өвдөлтийн үнэлгээ:	Өвдөлтийг тодорхойлох тоон хэмжээст үнэлгээ /NAS/	+	+	+	+
		Өвдөлтийн бусад нарийвчилсан стандарт асуумж, үнэлгээ	-	-	+	+
2	Үений далайцын үнэлгээ:	Гониометрийн үнэлгээ	+	+	+	+
		Туузан метрийн аргаар	+	+	+	+
		Үений	-	-	-	+

		далайцын кинематик үнэлгээ/хөдөлг өөний анализ хийх програм ашиглах/				
3	Булчингийн хүчний үнэлгээ:	Булчингийн хүчийг гараар үнэлэх /ММТ/	+	+	+	+
		Динамометр багажийн сорил	-	-	+	+
4	Бүх биеийн тэсвэрлэх чадварын үнэлгээ:	Амьсгалын хийн анализ /спирометр/	-	+	+	+
		Хөдөлгөөний ачаалалтай сорил	-	-	-	+
		Алхааны сорил (12 минут, 6 минутын сорил)	-	-	-	+
		Боргийн сорил	+	+	+	+
5	Өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ:	Бартелийн индекс (BI)	-	-	+	+
		Багажтай өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ (IADL), Катз	-	-	+	+
		Үйл ажиллагааны хараат бус байдал (FIM)	-	-	-	+
6	Багажийн	Булчингийн цахилгаан	-	-	+	+

	шинжилгээ:	бичлэг				
		Мэдрэл, яс, булчингийн хэт авиан шинжилгээ	-	-	+	+
		Уродинамик	-	-	+	+
7	Яс булчин, тулгуур эрхтний үйл ажиллагааны үнэлгээ:	Видеофлюороскопи	-	-	+	+
		Мэдрэл, яс булчингийн тогтолцооны хэвийн өсөлт хөгжил	+	+	+	+
		Морфометрийн үнэлгээ			+	+
		Рефлекс	+	+	+	+
		Мэдрэхүй	+	+	+	+
		Тэнцвэр: Статик (Суугаа, Зогсоо)	-	-	+	+
		Тэнцвэр: Динамик	-	-	+	+
		Эмгэг төрх байрлал	-	-	-	+
		Алхаа анализ: Ажиглалт, Кинетик	-	-	-	+
		Алхааны анализ: Кинематик	-	-	-	+
8	Зүрх судасны үйл ажиллаганы	Энерги зарцуулалтын анализ	+	+	+	+
		Ортез протезийн үнэлгээ	-	-	-	+
		Яс булчин, тулгуур эрхтэний бусад өвөрмөц сорилууд	-	-	-	+
		Зүрхний цохилт, судасны лугшилт тодорхойлох	+	+	+	+

	Үнэлгээ:	Амьсгалын тоо	+	+	+	+
		Артерийн даралт	+	+	+	+
		Захын цусны хүчилтөрөгчийн ханамж	+	+	+	+
		Хийн анализ	-	-	-	+
		Амьсгалын үйл ажиллагааны сорил	-	-	+	+
		Дасгалын эрчим тодорхойлох	-	-	+	+
		Алхааны сорил	-	-	+	+
		Ачаалал тодорхойлох сорил /Bruce/	-	-	-	+
		Зүрх судасны үйл ажиллаганы бусад өвөрмөц үнэлгээ	-	-	-	+
9	Тархи, мэдрэлийн үйл ажиллагааны үнэлгээ:	Булчингийн тонус	+	+	+	+
		Булчингийн цахилгаан бичлэг	-	-	-	+
		Саа саажилт	+	+	+	+
		Байрлалын хяналт	-	-	+	+
		Эмгэг төрх байрлал	-	-	-	+
		Эмгэг алхаа (Кинематик, Кинетик)	-	-	-	+
		Үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн үнэлгээ (Зорилгот үйлдэл)	-	-	-	+
		Харааны алдагдал	-	-	+	+
		Хэл залгиурын үйл ажиллагаа	-	-	-	+

		Зан үйл	-	-	-	+
		Танин мэдэхүйн үйл ажиллагаа	-	-	-	+
10	Хүүхдийн эмгэгийн үеийн үнэлгээ:	Хүүхдийн өсөлт хөгжлийн үнэлгээ (G)	-	-	-	+
		Хүүхдийн өсөлт хөгжлийн үнэлгээ (CS)	-	-	-	+
		Denver	-	-	-	+
		Эмгэг рефлекс	-	-	-	+
		Булчингийн тонус	-	-	-	+
		Төрх байдал	-	-	-	+
11	Дотоод шүүрлийн үнэлгээ:	Алхаа	-	-	-	+
		Зүрхний цохилт, судасны лугшилт тодорхойлох	-	-	-	+
		Амьсгалын тоо	-	-	-	+
		Артерийн даралт	-	-	-	+
		Захын цусны хүчилтэрөгчийн ханамж	-	-	-	+
		Эрсдлийн зэргийг тодорхойлох	-	-	-	+
		Хөдөлгөөний ачаалалтай сорил	-	-	-	+
12	Настны үнэлгээ:	Алхааны сорил (12 минут, 6 минутын сорил)	-	-	-	+
		Боргийн сорил	-	-	-	+
		Идэвхитэй үений далайц	-	-	-	+
		Булчингийн хүч	-	-	-	+
		Өдөр тутмын үйл ажиллагааны	-	-	-	+

		Үнэлгээ					
		Унах эрсдэл, Тэнцвэрийн үнэлгээ	-	-	-	-	+
13	Эмэгтэйчүүд ийн үнэлгээ:	Жирэмсний үеийн үнэлгээ	-	-	-	+	-
		Эмэгтэйчүүдийн эмгэгийн үеийн үнэлгээ	-	-	-	+	-
		Эмэгтэйчүүдийн ясны сийрэгжилт	-	-	-	+	-

10.2 Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх эмчилгээний нэр төрөл

№	Сэргээн засах эмчилгээний нэр төрөл	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, Сувилахуйн төв, Сувилал			Нэгдсэн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв,			Сэргээн засах төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай эмнэлэг		
		Цочмог үе (0-1 сар)	Цочмогдуу үе (1-бсар)	Архаг үе (6 сараас)	Цочмог үе (0-1 сар)	Цочмогдуу үе (1-бсар)	Архаг үе (6 сараас)	Цочмог үе (0-1 сар)	Цочмогдуу үе (1-бсар)	Архаг үе (6 сараас дээш)
1	Хэвтрийн дэглэм болон хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй үл ашиглах хам шинжийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээ	-	-	+	+	+	+	+	+	+
2	Мэс заслын өмнө, хойно үүсч болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээ	-	-	+	+	+	+	+	+	+
3	Үений сайжруулах далайц дасгал	-	+	+	+	+	+	+	+	+

	эмчилгээ (идэвхитэй болон идэвхигүй далайцын дасгал, сунгалт дасгал, үений мобилизаци)									
4	Булчингийн хүч хөгжүүлэх эсэргүүцэлтэй дасгал эмчилгээ (изометрик, икотоник, изокинетик, тулгууртай болон тулгуургүй кинетик дасгал)	-	+	+		+	+		+	+
5	Зохицолт хөдөлгөөн (координаци) сайжруулах дасгал	-	-	-	-	+	-	-	+	-
6	Булчинг хөдөлгөөнд эргэн сургах (мэдрэл булчинг дэмжих эмчилгээ, эргэн холбооны эмчилгээ)	-	-	-	-	+	-	-	+	-
7	Эмчилгээний дасгалууд	-	-	+	-	-	+	-	-	+
8	Биений тэсвэрлэх чадварыг сайжруулах дасгал эмчилгээ (аэробик болон анаэробик дасгал)	-	-	+		+	+		+	+
9	Тэнцвэр сайжруулах (статик, динамик) өвөрмөц дасгал	-	-	+	-	+	+	-	+	+
10	Эмгэг төрх байдал засах дасгал	-	-	-	-	+	+	-	+	+
11	Эмгэг алхаа засах дасгал	-	-	+	+	+	+	+	+	+
12	Өдөр тутмын үйл ажиллагааны дасгал	-	+	+	-	+	+	-	+	+
13	Үндсэн хөдөлгөөний дасгал эмчилгээ (хэвтэх, хөрвөх, өндийх, суух, босох,	-	+	+	+	+	+	+	+	+

	зогсож)									
14	Зөв байрлалын дасгал	+	+	+	+	+	+	+	+	+
15	Шилжих хөдөлгөөн (орноос босох, суугаа байдлаас босох, байрлал сольж суух) сайжруулах дасгал	+	+	+	+	+	+	+	+	+
16	Параллел бар, тэргэнцэр болон алхааны туслах хэрэгсэлтэй шилжих хөдөлгөөний дасгал	-	+	+	+	+	+	+	+	+
17	Туслах хэрэгсэлгүй алхах дасгал	-	+	+	+	+	+	+	+	+
18	Үйл ажиллагааны хөдөлмөр засал	-	-	+	-	+	+	-	+	+
19	Хиймэл эрхтэн (хиймэл гар хөл) зүүх, дасан зохицох, хэрэглэх дасгал	-	-	+	-	+	+	+	+	+
20	Ортез, протез, туслах хэрэгсэл (дээд, доод мөч, их биеийн хэрэгсэл) зүүх, дасан зохицох, хэрэглэх дасгал	-	-	+	-	+	+	+	+	+
21	Тэргэнцэр, таяг, алхах хэрэгсэл ашиглах дасгал	-	+	+	+	+	+	+	+	+
22	Өөрт туслах хэрэгсэл ашиглаж өдөр тутмын амьдралын чадвар сайжруулах дасгал	-	+	+	+	+	+	+	+	+
23	Иллэг, цэгэн бария, гар засал	-	-	+	+	+	+	+	+	+
24	Татлага	-	-	-	-	-	+	-	-	+

25	Дулааны хүчин зүйлийн эмчилгээ	-	+	+	+	+	+	+	+	+
26	Гэрлийн эмчилгээ	-	-	+	-	+	+	-	+	+
27	Усан эмчилгээ	-	-	-	-	+	+	-	+	+
28	Цахилгаан эмчилгээ (эмчилгээний цахилгаан цочруул: TES)	-	-	-	-	-	-	-	+	+
29	Цахилгаан эмчилгээ (үйл ажиллагааны цахилгаан цочруул: FES)	-	-	-	-	+	-	-	+	+
30	Цахилгаан эмчилгээ (Арьсаар дамжих цахилгаан мэдрэлийн цочруул: TENS)	-	-	-	-	+	+	-	+	+
31	Шокын эмчилгээ	-	-	-	-	+	+	-	+	+
32	Мэдрэлийн хориг эмчилгээ (булчингийн доторх мэдрэлийн фенолын болон ботулины хориг)	-	-	-	-	-	-	-	+	+
33	Өвдөлт намдаах эмчилгээ	-	-	-	-	+	+	-	+	+
34	Өвдөлтийн менежмент	-	+	+	+	+	+	+	+	+
35	Эхо хяналтанд мэдрэл, үе болон зөвлөн эдэд тарилга хийх	-	-	-	-	+	+	-	+	+
36	Зөөврийн рентген хяналтат тарилга	-	-	-	-	+	+	-	+	+
37	Хэл ярианы чадвар сайжруулах	-	-	-	-	-	-	+	+	-
38	Үйл ажиллагааны эмчилгээ (цочроох)	-	-	-	-	+	-	+	+	-
39	Харилцааны чадварыг сайжруулах эмчилгээ (харилцааны самбар, дохио зэрэг угэн бус)	-	-	+	+	+	+	+	+	-

	харилцааны арга ашиглах)									
40	Танин мэдэхүйн чадвар сайжруулах эмчилгээ	-	-	+	-	+	+	-	+	+
41	Сэтгэл засал	-	+	+	+	+	+	+	+	+
42	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	-	-	-	-	-	-	+	+	+
43	Эрүүл мэндийн боловсрол олгох	-	+	+	+	+	+	+	+	+
44	Эмнэлгээс гаргах төлөвлөгөө боловсруулах	-	-	-	+	+	-	+	+	-
45	Гэр бүл, асран хамгаалагчийн оролцоо, дэмжлэгийг бий болгох	-	+	+	+	+	+	+	+	+

Эрүүл мэндийн сайдын 2019 оны ...
дугаар сарын 08. өдрийн ~~Аж~~ дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг багасгах, орны хүлээгдлийг бууруулах, өвчтөний сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.
- 1.2. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ гэдэгт эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас батлагдсан
 - 1.2.1. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний жагсаалт, журам
 - 1.2.2. Эмнэгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусlamж, үйлчилгээний жагсаалт, журам
 - 1.2.3. Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээний заавар”
 - 1.2.4. Сэргээн засах төв, сувилалд үзүүлэх тусlamж, үйлчилгээний жагсаалт, журамд заасан өдрийн тусlamж, үйлчилгээг хамааруулна.
- 1.3. Өдрийн тусlamж, үйлчилгээ гэж өвчний учир үйлчлүүлэгчид мэс заслын болон мэс заслын бус тусlamж, үйлчилгээг эмнэлэгт хонуулахгүйгээр эмчийн хяналтанд үзүүлэхийг хэлнэ.
- 1.4. Өдрийн эмчилгээ, үйлчилгээг анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага хийж гүйцэтгэх бөгөөд байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандарт болон эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналтын журам, заавар, удирдамжийг мөрдөн ажиллана.
- 1.5. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгал болон улсын төсөв, төлбөртэй тусlamж, үйлчилгээний холбогдох тогтоол, журмаар зохицуулна.

Хоёр. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний зохион байгуулалт

- 2.1. Эрүүл мэндийн байгууллага нь өдрийн эмчилгээ, үйлчилгээг үзүүлэхэд өөрийн үйл ажиллагааны онцлог, хүчин чадалдаа уялдуулан, тусlamж, үйлчилгээний хэрэгцээ, ачаалал, эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааварт үндэслэн эмнэлгийн мэргэжилтний орон тоог зохистой байдлаар хуваарилалт хийж, удирдах, хяналт тавих зохион байгуулалтыг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 2.2. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгааг, үйл ажиллагаа, үндсэн мэргэшлийн чиглэл, онцлог, эрэлт хэрэгцээтэй нийцүүлэн тусlamж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай багаж хэрэгслийг зохистой бүрдүүлж, яаралттай тусlamжийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршуулж, эмчилгээний хяналт, зөвлөгөө мэдээллээр хангах холбоо барих хэрэгслээр тоноглон, үйлчилгээ үзүүлэгчийн сэтгэлд нийцсэн орчныг бүрдүүлнэ.
- 2.3. Тусlamж, үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгааны хэсэгт үйлчилгээ үзүүлэгчийн танилцуулга, үйл ажиллагаа, өдрийн эмчилгээ, үйлчилгээний талаар үйлчилүүлэгчид ойлгомжтой хэлбэрээр тайлбарласан мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Гурав. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамруулах заалт

- 3.1. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд эмнэлгийн мэргэжилтний хяналтанд уух эм, тарилга, өдрийн мэс засал, хэвлийн диализ, гемодиализ, хими, туяа, лазер эмчилгээ болон уламжлалт, сэргээн засах тусlamж, үйлчилгээ хамаарна. Дараах шаардлагыг үндэслэн өдрийн эмчилгээнд хамруулна. Үүнд:
- 3.1.1. Өвчтөний онош, шинжилгээ, эмнэлзүйгээр батлагдсан байх;
 - 3.1.2. Өвчтөний өвчин эмгэг нь амь насанд нь аюул учруулахгүй байх;
 - 3.1.3. Өдрөөр хийгдсэн эмчилгээ, үйлчилгээний дараа ажиглалтын хугацаа дуссаад өвчтөн гэртээ эргэн харихад бүрэн чадамжтай байх;
 - 3.1.4. Бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний явцад байнгын асран халамжлагчтай байх;
 - 3.1.5. Өвчтөн хэвтрэйн дэглэм сахих заалтгүй байх;
 - 3.1.6. Өвчтөн 24 цагийн дотор эмнэлэгт давтан үзүүлэх шаардлагагүй байх;
 - 3.1.7. Мөн 24 цагийн туршид мэргэжлийн сувилахуйн тусlamж, үйлчилгээ авах шаардлагагүй байх;
 - 3.1.8. Тухайн өвчтөнд үзүүлэх өдрийн эмчилгээ, үйлчилгээний давтамж 10 өдрөөс хэтрэхгүй, сард нэгээс илүүгүй байх;
 - 3.1.9. Өвчтөн болон асран хамгаалагч нь холбоо барих утастай байх.
- 3.2. Өдрийн мэс засал хийх тохиолдол бүрд үйлчилүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчөөс батлагдсан маягтын дагуу шийдвэрийг гаргуулж өвчний түүхэнд хавсаргасан байна.
- 3.3. Хорт хавдар, хими эмчилгээг тухайн өвчтөнд курсээр давтан хийхдээ эхний нээсэн өвчний түүхийг үргэлжлүүлэн хөтөлж болно.

Дөрөв. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдахгүй заалт

- 4.1. Эмчийн бичсэн жороор гэрээр ууж хэрэглэх эм, мэс засал, өвчний түүх нээх шаардлагагүй амбулатороор хийх жижиг мэс ажилбар нь өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамаarahгүй. /Энэ заалт нь хүүхдэд хамаarahгүй/
- 4.2. Дараах тохиолдолд үйлчлүүлэгчийг өдрийн эмчилгээ үйлчилгээнд хамруулахгүйгээр тусlamж, үйлчилгээний бусад тохирох хэлбэрийг сонгон үйлчилнэ. Үүнд:
 - 4.2.1. Эмчийн хяналтанд 24 цаг байх шаардлагатай үед;
 - 4.2.2. Хэвтрийн дэглэм сахих шаардлагатай, өвчтөний биеийн байдал хүнд, өвчний явц хүндрэх тохиолдолд;
 - 4.2.3. Шөнийн цагаар дахираг, хурц өвдөлт өгдөг өвчний үед;
 - 4.2.4. Эмчилгээний хоолны дэглэм онцгой шаардлагатай;
 - 4.2.5. Амбулаториор хийх, жижиг ажилбар;
 - 4.2.6. Эдийн шинжилгээнээс бусад оношилгоо, шинжилгээ;
 - 4.2.7. Эмчийн жороор эмийг гэрээр уух боломжтой, өвчтөний биеийн байдал хөнгөн бол хамрагдахгүй.